



ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ЦАГДААГИЙН БАГТ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЛБА ХААГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ШАЛГУУР

Суурь шалгуур:

1.Нас: Цагдаагийн багт үүрэг гүйцэтгэх алба хаагч 18-аас дээш 55-аас доош насны алба хаагч байх.

2.Ажлын туршлага: Удирдах бүрэлдэхүүн 10-аас дээш жил /удирдах албан тушаалд 2-оос дээш жил/, ажиллагааны, холбогч, жижүүрийн офицер, ар тал, хангалтын алба хаагч 6-аас дээш жил, салаа, тасгийн алба хаагч нь 2-аас дээш жил ажилласан байх.

3.Цол: Багийн захирагч, орлогч, цагдаагийн хошуучаас дээш, ажиллагааны, холбогч, жижүүрийн офицер цагдаагийн ахмадаас дээш, салааны дарга ахлах дэслэгчээс дээш, ар тал, хангалтын алба хаагч ахлагчаас дээш /ажлын туршлага, гадаад хэл харгалзана/ цолтой байна.

4.Бие бялдар, эрүүл мэнд: Эрсдэлтэй, хүнд нөхцөл байдалд бие бялдар, сэтгэлзүй, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл, үр дүнтэй, үүрэг гүйцэтгэх чадвартай байх.

Мэргэжлийн чадвар:

1.Мэргэжлийн мэдлэг: НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа, НҮБ-ын Бодлого, Ажиллагааны мандат, нэмэлтээр багийн удирдлага нь ажиллагааны үед нийтийн хэв журам сахиулах, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах мэдлэгтэй байх.

а/НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа: Цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн нь энхийг сахиулах ажиллагаа, түүний зарчим, энхийн ажиллагааны чиг үүрэг, бүтэц, холбогдох бодлого, үйл ажиллагааны мэдлэгтэй байх.

б/НҮБ-ын бодлого: Цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн нь НҮБ-ын Цагдаагийн албаны чиг үүрэг, хариуцлага, зарчим, бодлого, холбогдох заавар, суурь үзэл баримтлал, голлох хууль, эрх зүйн систем, практик хэтийн төлөв болон бусад үйл ажиллагааны журмын мэдлэгийн бүрэн ойлголттой байх.

в/Ажиллагааны мандат: Цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн нь аль ч энхийн ажиллагааны ойлголттой байх, мөн түүнчлэн ажиллагаа тус бүрт зориулсан үйл ажиллагааны журмын мэдлэгтэй байх.

г/Тусгай мэдлэг, ур чадвар: Цагдаагийн багийн захирагч, захирагчийн орлогч, салаа, тасгийн дарга, ажиллагааны офицер нь тактикийн ажиллагаа, нийтийн журам сахиулах удирдлага зохион байгуулалт, шийдвэр гаргах, стресс, айдсын менежмент, албаны сургалт, тактик ажиллагааны зуучлал болон хэлэлцээр хийх, орчуулагчийн дэмжлэг авах, албан тушаалын чиг үүрэгт хамаарах бусад ур чадвартай байх.

Гадаад хэлний мэдлэг:

1.Цагдаагийн багийн захирагч, захирагчийн орлогч, салааны дарга, ажиллагааны, холбогч, жижүүрийн офицер, ар тал, хангалтын алба хаагч нь тухайн ажиллагаанд тавигдах гадаад хэлний анхан дунд /B1/ шатны мэдлэгтэй байх.

2.Тасгийн дарга, эмч нь тухайн ажиллагаанд тавигдах гадаад хэлний ахисан анхан /A2/ шатны мэдлэгтэй байх.

3.Бусад алба хаагчид тухайн ажиллагаанд тавигдах гадаад хэлний анхан /A1/ шатны мэдлэгтэй байх.



Жолоодох ур чадвар:

1.Цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн нь механик хурдны хайрцагтай автомашин жолоодох чадвартай, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх шалгалт зохион байгуулагдахаас 2 жилийн өмнө олгогдсон байх.

а/Өдрийн гэрэлд 20,5 метр зайнаас 79,4 мм өндөртэй бичигдсэн тээврийн хэрэгслийн дугаарыг таних харааны чадвартай байх. /нүдний шилтэй байхыг зөвшөөрнө/

б/Тээврийн хэрэгслийг стандарт авто дром дээр хоёр төрөл /90 градус болон 45 градус/-оор ухрааж байрлуулах чадвартай байх.

в/ Хотын жолоодлогын ур чадвартай байх.

Галт зэвсэг ашиглах ур чадвар:

1.Цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн нь галт зэвсэг, аминд үл хүрэх зэвсгийн аюулгүй ажиллагааны талаар болон шаардлагатай тохиолдолд ашиглах мэдлэг, ур чадвартай байх ёстой. /Гар буу, хагас автомат карабин буу, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, резинэн, хуванцар сумтай буу орно./

2.Буудлага үйлдэх, галт зэвсэгтэй харьцах, эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

Тайлбар:НҮБ-ын Цагдаагийн албанаас “Цагдаагийн баг”-ийг үнэлэх баг хүрэлцэн ирж албан тушаалд тавигдах шаардлага, шалгуур тус бүрээр алба хаагч бүрийг үнэлж, дүгнэх юм.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

НҮБ-ын үйл ажиллагааны “Цагдаагийн багийн үүрэг гүйцэтгэх чадавхийг үнэлэх журам /Assessment of Operational Capability of Formed Police Units For Service in United Nations Peacekeeping operations and Special Political Missions/”-аас...